

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 03 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссын шийдвэрийг баримтлан 2021 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийг дуустал үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулж ажиллав.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Виз, зөвшөөрлийн чиглэлээр:

1.1.1. Гадаадын иргэнд үзүүлсэн виз, визийн зөвшөөрлийн үйлчилгээ:

Тайлант хугацаанд 699 гадаадын иргэнд визийн зөвшөөрөл олгож, үүнээс 575 иргэний визийн зөвшөөрлийг Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газарт, хилийн боомтод виз олгох 124 иргэний визийн зөвшөөрлийг хилийн боомт, бүсийн газруудад илгээлээ. (Хүснэгт 1)

Түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн 147 гадаадын иргэнд хилийн боомтод, 2 иргэнд төвд зохих ангиллын Монгол Улсын виз олгосон. Мөн 2 иргэнд визийн шилжүүлэг, 1 иргэнд гарах-орох цагаачийн мэдэгдэл, 2 иргэнд хувийн урилга олголоо. (Хүснэгт 1)

Хүснэгт 1

Визийн зөвшөөрөл		Виз	Оршин суух зөвшөөрөл			Түр ирэгч	
Хилийн чанадад	Хилийн боомтод		олгосон	сунгасан	хэлбэр, төрөл өөрчилсөн	хаягийн бүртгэл	байх хугацаа сунгалт
575	124	149	316	561	6	81	51
699							

2022 оны 02 дугаар сард нийт 274 аж ахуйн нэгж, байгууллагын 785 гадаадын иргэний хүсэлтийг цахим (eimmigration.mn)-аар хүлээн авч, холбогдох хууль, журмын дагуу хянан, шийдвэрлэлээ.

“evisa.mn” цахим системээр нийт 19 улсын 95 иргэнд цахим виз олгож, 1 улсын 2 иргэний визийн хүсэлтэд татгалзсан.


1.1.2. Гадаадын иргэний бүртгэл, хяналт:

Эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэн 316 гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, 561 иргэний оршин суух зөвшөөрлийн

хугацааг сунган, оршин суух зөвшөөрөлтэй 166 иргэний бүртгэлд хасалт хийж, 6 иргэний оршин суух хэлбэрийг солих үйлчилгээ үзүүллээ. (Хүснэгт 1)

Гадаадын иргэнийг уригч 8 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу 11 гадаадын иргэнд виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгож, Монгол Улсад түр ирэгчээр ирсэн 81 гадаадын иргэнийг хаягийн бүртгэлд бүртгэсэн. Мөн Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн болон визгүй зорчдог түр ирэгч гадаадын иргэдээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 51 иргэний байх хугацааг 30 хүртэл хоногоор сунгасан. (Хүснэгт 1)

График 1



Дээрх тоон үзүүлэлтийг 2021 оны үзүүлэлттэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 106,0 хувь, оршин суух зөвшөөрөл олголт 23,6 хувиар өсөж, виз олголт 80,5 хувь, оршин суух зөвшөөрлийн сунгалт 19,3 хувиар тус тус буурчээ.

Цахим хэлбэртэй “Монгол Улсад оршин суух үнэмлэх” 731 ширхэг шинээр хэвлэж, 215 үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунган, 6 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ.

Оршин суух зөвшөөрөл авах болон оршин суух зөвшөөрлөө сунгуулах хүсэлт ирүүлсэн гадаадын 145 иргэний хүсэлтийг шийдвэрлэж, гадаадын 12 иргэнд регистрийн дугаар олгосон.

1.1.3. Зөвлөгөө, мэдээлэл:

Тайлант хугацаанд гадаадын иргэний Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл, түүний сунгалт, түр ирэгчийн бүртгэл, хасалт, визийн хугацааны сунгалтын асуудлаар нийт 1939 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

1800-1882 утас	Биечлэн	Фэйсбүүк хуудас чат	Автомат хариулагч	Имэйл	Нийт
1560	101	35	223	20	1939

Код мессеж үйлчилгээг 325 иргэнд хүргэж, 5 гадаадын иргэнд паспорт, 780 иргэнд оршин суух үнэмлэхийг буцаан олголоо.

1.2. Иргэний харьяаллын чиглэлээр:

1.2.1. Иргэний харьяалал:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 15 дугаар зарлигаар Оросын Холбооны Улсын иргэн Дандарова Дашима Монгол Улсын харьяат болсон байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3

Хугацаа	Монгол Улсын харьяат болсон	Иргэний харьяаллыг сэргээн тогтоосон	Монгол Улсын харьяатаас гарсан	Хоёрдмол харьяалалтай иргэнийг бүртгэсэн
02 дугаар сар	1	-	-	13
2022 он /өссөн дүнгээр/	1	-	-	45

Харьяатын асуудлаар 8 иргэн, 3 харьяалалгүй хүний хүсэлтийг хүлээн авч, 8 иргэн, 3 харьяалалгүй хүний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас санал авах ажиллагааг явууллаа.

Түүнчлэн 21 иргэн, 3 харьяалалгүй хүний баримт бичигт дүгнэлт үйлдэж, Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, 14 иргэн, 2 харьяалалгүй хүний хүсэлт, баримт бичиг, санал, дүгнэлтийг Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлсэн. (Хүснэгт 4)

Хүснэгт 4

Иргэний харьяаллын талаарх сарын мэдээ						
д/д	Харьяалах улс	Хүлээн авсан хүсэлт	Түдгэлзүүлж буцаасан хүсэлт	Саналд илгээсэн	ЗГХЭГ-т хүргүүлсэн	ЕТГ-т хүргүүлсэн
Монгол Улсын харьяат болох						
1	Хятад	1	-	1	-	-
нийт		1	-	1	-	-
Монгол Улсын харьяатаас гарах						
1	Австри	3	-	4	-	1
2	Казахстан	-	-	-	3	3
3	Өмнөд Солонгос	1	-	1	2	3
4	Герман	2	-	1	10	6
5	Сингапур	1	-	1	-	-
6	Япон	-	-	-	6	1
нийт		7	-	7	21	14
Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох						
1	Харьяалалгүй хүн	3	-	3	3	2
нийт		3	-	3	3	2

Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд 02 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор 52 улсын 3945 хоёрдмол харьяалалтай иргэн бүртгэлтэй байна. Тайлант хугацаанд хоёрдмол харьяалал үүсгэсэн 13 иргэнийг шинээр бүртгэжээ. (Хүснэгт 3)

Бүгд Найрамдах Казакстан Улсын Элчин сайдын яамны ноот бичгийг үндэслэн 2 иргэнийг “Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-д хоёрдмол харьяалал үүсгэсэн бүртгэлээс хасалт хийлээ.

1.2.2. Хүүхэд үрчлэлт:

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын иргэн, гэр бүлд үрчлэгдсэн нийт 3 хүүхдийн тайланг хүлээн авч, мэдээллийн санд бүртгэсэн.

2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар Монгол Улсаас гадаадын иргэн, гэр бүлд нийт 274 Монгол хүүхэд үрчлэгдээд байна.

1.2.3. Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын бүртгэл, хяналт:

Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн 5 байгууллагын хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авч, үйл ажиллагаа эрхэлж байгаа 58 байгууллагын үйл ажиллагааны тайланг хүлээн авсан.

Байгууллагын “Мэргэжлийн зөвлөл”-ийн 02 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар хүсэлт ирүүлсэн нийт 6 олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлт (зөвшөөрлийн хугацааг сунгуулах 6)-ийг хэлэлцүүлж, шийдвэрлэв.

1.3. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:

1.3.1. Гадаадын иргэнд тавих хяналт шалгалт:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэн болон хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/354 дүгээр, мөн сарын 28-ны өдрийн 01/440 дүгээр албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлсэн.

Тайлант хугацаанд төлөвлөгөөт 2 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, 41 гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийг шалгахад зөрчил илрээгүй байна.

Мөн төлөвлөгөөт бус 5 удаагийн хяналт шалгалтаар 9 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 9 иргэнийг хамруулан, нийт 2 зөрчлийг илрүүлж, Зөрчлийн тухай хуулиар торгох шийтгэл оногдуулсан.

Нутаг дэвсгэрт оршин суух үнэмлэх эзэмших, ашиглах, хадгалах журам, паспорт, паспортыг орлох баримт бичиг, эсхүл оршин суух үнэмлэхээ биедээ авч явах журам болон хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 7, Бүгд Найрамдах Словак Улсын 1, Оросын Холбооны Улсын 1, нийт 9 гадаадын иргэнд Зөрчлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт зааснаар 900,000 төгрөг (Есөн зуун мянган)-ийн торгох шийтгэл оногдууллаа. (Хүснэгт 5)

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасан гомдол, мэдээллийг хүлээн авч, бүртгэх, шийдвэрлэх зорилгоор 70133448 дугаар утасны

үйлчилгээг ажиллуулж байна. Тайлант хугацаанд зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл бүртгэгдээгүй.

Хүснэгт 5

Зөрчлийн мэдээ (тухайн сард)							
Хувь хүнээр		Уригч байгууллагаар			Уригч хувь хүнээр		
Иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч байгууллага	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч иргэн	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/
9	900,000	-	-	-	-	-	-
Шийтгэлийн төрөл							
Хуулийн үндэслэл	Шалтгаан			Торгуулийн хэмжээ (төгрөг)	Гадаадын иргэний тоо		
Зөрчлийн тухай хууль 16.2-1.2	нутаг дэвсгэрт оршин суух үнэмлэхийг эзэмших, ашиглах, хадгалах журам зөрчсөн			700,000	7		
Зөрчлийн тухай хууль 16.2-1.3	нутаг дэвсгэрт паспорт, паспортыг орлох баримт бичиг, эсхүл оршин суух үнэмлэхээ биедээ авч явах журам зөрчсөн			100,000	1		
Зөрчлийн тухай хууль 16.2-1.4	нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн			100,000	1		
нийт				900,000	9		

1.3.2. Хориг арга хэмжээ:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.11 дэх заалт (шүүхээр ял шийтгүүлсэн гадаадын иргэн ялаа эдэлж дууссан буюу ялаас чөлөөлөгдсөн)-ыг үндэслэн Бүгд Найрамдах Солонгос Улсын 1 иргэнийг байгууллагын даргын даргын 02 дугаар сарын 21-ний өдрийн А/30 дугаар тушаалаар 3 жилийн хугацаагаар албадан гаргахаар шийдвэрлэлээ. (Хүснэгт 6)

Хүснэгт 6

Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний мэдээ (тухайн сард)					
№	Улс	Зүйлчлэл			Нийт
		37.1.2	37.1.11	37.1.12	
1	Өмнөд Солонгос	1			1
	Бүгд	1	1	2	4

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.10 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 193 дугаар тогтоолоор баталсан "Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам"-ын 6.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1 иргэнийг байгууллагын даргын тушаалаар Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг сунгасан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх заалт (гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан бол эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл)-аар түдгэлзүүлсэн Бүгд Найрамдах Солонгос Улсын 1 иргэн, мөн хуулийн 34.2.3 дахь заалт (тухайн гадаадын иргэнийг Монгол Улсаас гарах, гарахыг түр

түдгэлзүүлэх тухай шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол)-аар түдгэлзүүлсэн Бүгд Найрамдах хятад Ард Улсын 2 иргэнийг байгууллагын даргын нийт 2 удаагийн тушаалаар Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлснийг хүчингүй болгож, хилээр нэвтрэх эрхийг сэргээлээ.

График 2



2022 оны 02 дугаар сарын тоон үзүүлэлтийг 2021 оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 4,2 дахин, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 60,0 хувь өсөж, албадан гаргасан гадаадын иргэн 44,4 хувь, саатуулсан гадаадын иргэн 33,3 хувиар тус тус буурсан байна.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

2.1.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, төлөвлөгөө, тайлан:

Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, хөгжлийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврын хүрээнд “Төрийн бүтээмжийн сэргэлтийн ерөнхий төлөвлөгөө”-д тусгах саналыг 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/329 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

2010 оноос хойших хугацаанд байгууллагад нэвтрүүлсэн цахим засаглал, харилцаа холбоо, инновац, өндөр технологитой холбоотой мэдээллийг 02 дугаар сарын 11-ний өдрийн 01/353 дугаар, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан цахим технологитой холбогдох арга хэмжээний хэрэгжилтийг 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/431 дүгээр албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 01 дүгээр сарын 31-ний өдрийн Шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг 02 дугаар сарын 17-ны өдрийн 01/377 дугаар албан бичгээр болон цахимаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

Байгууллагын 01 дүгээр сарын тайланг боловсруулж, тоон мэдээг инфографик хэлбэрээр 02 дугаар сарын 07-ны өдрийн 01/329 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд мөн хүргүүлээ.

Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 02 дугаар сарын 28-ны өдөр, байгууллагын дэд даргын санаачилгын дагуу байгууллагын үйл ажиллагаанд шинэ санал, дэвшилтэд инноваци нэвтрүүлэх зорилготой “Шинэ санаа-шилдэг инноваци” уралдааны удирдамжийг мөн өдөр тус тус баталсан.

2.1.2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөц, сургалт:

Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагад ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэний холбогдох мэдээллийг 02 дугаар сарын 01-ний өдрийн 02/302 дугаар, Хууль зүйн салбарын шагналд нэр дэвших болзол хангасан 20 албан хаагчийн анкет, тодорхойлолтыг хурлын тэмдэглэлийн хамт 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/325 дугаар албан бичгээр Хууль, зүй дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлэв.

Байгууллагын нэгжийн удирдах албан тушаалтанд эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийг ахиулан олгох саналыг 02 дугаар сарын 11-ний өдрийн 01/345 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлд, төрийн захиргааны албан хаагчдад дэс түшмэлийн зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох саналыг мөн өдрийн 01/346 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

Байгууллагын албан хаагчдын 2017-2019 онд төрсөн 23 хүүхдийг цэцэрлэгт хамруулахтай холбогдуулан судалгааг 02 дугаар сарын 14-ний өдрийн 03/358 дугаар албан бичгээр Нийслэлийн Хан-Уул дүүргийн 223 дугаар цэцэрлэгт хүргүүлэв.

Мэдүүлэг гаргагч нийт 201 албан тушаалтнуудын 2021 оны шинэчлэн гаргасан мэдүүлгийг хуулийн хугацаанд нь бүртгэж, “ХАСХОМ-ийн 2022 оны тайлан”-г 02 дугаар сарын 21-ний өдрийн 01/390 дүгээр албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв.

Байгууллагын 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хэрэглэгчийн үнэлгээний судалгааны тайланд ирүүлсэн зөвлөмжийн дагуу 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 02 дугаар сарын 08-ны өдөр баталсан.

Байгууллагын даргын 02 дугаар сарын 22-ны өдрийн Б/52, Б/53, Б/54, Б/55 дугаар тушаалаар Зүүн бүс дэх газрын хяналтын улсын ахлах байцаагч 2, Өмнөд бүс дэх газрын хяналтын улсын байцаагч 1, Хойд бүс дэх газрын виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн 1 буюу нийт 4 албан хаагчид Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8 дахь хэсэгт заасан хилийн боомт, орон нутаг дахь албанд 5-аас доошгүй жил ажиллаж байгаа ажилтанд ажилласан 5 жил тутам 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулалд нийт 100,684,171 төгрөгийг олгохоор шийдвэрлэлээ.

Мөн байгууллагын даргын 02 дугаар сарын 22-ны өдрийн Б/51 дугаар тушаалаар төрийн захиргааны болон үйлчилгээний 7 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгохоор шийдвэрлэв.

Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн системд бүртгэлтэй төвийн 122 албан хаагчийн ажилласан жил, ажиллаж байсан газрын мэдээллийг бүртгэж, баталгааны хуудсыг 02 дугаар сарын 23-ны өдөр Төрийн албаны зөвлөлд цахимаар хүргүүлсэн.

2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ, төрийн албанд ажилласан жил, тухайн албан тушаалын шаардлага, эрхэлж буй албан тушаалын ангилалд хамаарах зэрэг дэвтэй 204 албан хаагчийн судалгааг нэгтгэхэд 02 дугаар сарын байдлаар 5 албан хаагч эрхэлсэн түшмэлийн, 61 албан хаагч ахлах түшмэлийн, 77 албан хаагч дэс түшмэлийн буюу төрийн захиргааны нийт 143 албан хаагч зэрэг дэв тогтоолгосон байгаа нь өмнөх оноос 1.6 хувиар өссөн байна.

Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон Дорноговь аймаг дахь газрын үйлчлэгч С.Энхтайванд холбогдох хууль, тогтоомжийг баримтлан байгууллагын даргын Б/39 дүгээр тушаалаар 17 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж болох 8,897,885 төгрөгийг олгосон.

Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (ERP)-ийг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор зохион байгуулалтын нэгжийн ахлах мэргэжилтэн, өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн, архив-бичиг хэргийн ажилтан болон бичээч нарын 36 албан хаагчийг хамруулсан цахим сургалтыг 02 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулав.

“Хүмүүн байхын учир ёс суртахуунд нь оршвой” сэдэвт сургалтыг 02 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж, Монгол Улсын Төрийн Шагналт, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Академич, МУИС-ийн Эмерит профессор, Япон улсын Нагоягийн Их Сургуулийн хүндэт доктор С.Нарангэрэл хичээл заалаа. Сургалтад төв, орон нутаг дахь нэгжийн 188 албан хаагч хамрагдав.

Монгол Улсын Терроризмтой тэмцэх зөвлөлтэй хамтран 02 дугаар сарын 18-ний өдөр “Террорист этгээдийн хөдөлгөөн ба олон улсын терроризмын нөхцөл байдал” сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургалтад төв, орон нутаг дахь нэгжийн нийт 103 албан хаагч, 02 дугаар сарын 17,18-ны өдрүүдэд зохион байгуулсан мэдээллийн технологийн инженерүүдийн мэргэжлийн сургалтад нийт 14 албан хаагч тус тус хамрагдаа.

Хөгжлийн төлөөх Египетийн түншлэлийн агентлагаас 03 дугаар сарын 05-аас 31-ний өдрүүдэд зохион байгуулах “Хүний наймаа, хууль бус цагаачлал, хилийн боомтын аюулгүй байдал” сэдэвт сургалтад хамрагдах 2 албан хаагчийн мэдээллийг 02 дугаар сарын 24-ний өдрийн 01/422 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

2.1.3. Олон нийт, хэвлэл мэдээлэл:

Тайлант хугацаанд байгууллагын цахим сайтад үйл ажиллагаатай холбоотой 9 мэдээ, мэдээллийг байршуулж, 21 хэвлэл мэдээллийн хэрэгсэл (1 телевиз, 2 сонин, 18 сайт)-ээр сурталчилсан.

Байгууллагын цахим хуудас (фейсбүүк, твийтэр), emmigration аппликэйшнд баяжилтыг хийж, байгууллагын үйл ажиллагаа болон үйлчилгээ авахтай холбоотой нийт 34 мэдээллийг байршууллаа.

Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг, байгууллага болох Дотоод хэргийн их сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон Хил хамгаалах ерөнхий газрын мэргэжлийн студитэй хамтран ажиллах тухай саналыг 02 дугаар сарын 10-ны өдрийн 03/316 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

2.2.1. Хууль, эрх зүй:

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд оруулах саналыг 02 дугаар сарын 21-ний өдрийн 01/369 дүгээр, “Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журам”-ын төсөлд тусгах саналыг 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/361 дүгээр, Засгийн газрын 62 дугаар тэмдэглэлд тусгагдсан заалтын биелэлтийг 02 дугаар сарын 22-ны өдрийн 03/388 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

“Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/08 дугаар тушаалаар батлагдсантай холбогдуулан 2016 оны А/241 дүгээр тушаалаар баталсан “Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”-ыг байгууллагын даргын 02 дугаар сарын 14-ний өдрийн А/27 дугаар тушаалаар хүчингүй болгон, шинэчлэн батлуулж, шийдвэрийг 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/361 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээ.

Иргэн О.Энхбаатарын нэхэмжлэлтэй холбогдуулан 02 дугаар сарын 25-ны өдрийн “Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг тодруулах тухай” 01/430 дугаар албан бичгийг Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлэв.

2.2.2. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:

Байгууллагын дарга 02 дугаар сарын 15-ны өдөр Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдтай, мөн сарын 16-ны өдөр Оросын Холбооны Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдтай, 17-ны өдөр Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдтай, 22-ны өдөр Бүгд Найрамдах Польш Улсын Элчин сайдтай тус тус зохион байгуулсан уулзалтаар хоёр улсын хамтын ажиллагаа, хэрэгжүүлж буй бодлого, иргэдийн зорчих хөдөлгөөн, албан хаагчдыг чадавхжуулах богино, дунд хугацааны сургалтын талаар санал солилцлоо.

Мөн байгууллагын дарга 02 дугаар сарын 22-ны өдөр Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/-ын Монгол Улс дахь суурин төлөөлөгчтэй 2007 оноос хойших хоёр байгууллагын

хамтын ажиллагаа болон олон улсын жишигт нийцсэн программ хангамж, техник технологи, цахим гарцыг амжилттай нэвтрүүлсэн асуудлаар цахим уулзалтыг зохион байгуулав.

Байгууллагын Дэд дарга Оросын Холбооны Улсын ЭСЯ-тай хамтран Монгол Улсад оршин сууж байгаа Орос Улсын иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчийн газрын төлөөллийг оролцуулан “Шинэ сэргэлтийн бодлого ба эрх зүйн орчны талаарх танилцуулга” сэдэвт уулзалт, арга хэмжээг 2 дугаар сарын 25-ны өдөр зохион байгууллаа.

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Монголын аялал жуулчлалын холбоо, Нийслэлийн аялал жуулчлалын газартай хамтран 02 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан “Tourism time” арга хэмжээнд Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Мэдээллийн технологийн хэлтсийн дарга нар цахим виз, хилийн боомтод олгож буй визийн зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгч оролцлоо.

Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын НАБЯ-ны харьяа Шилжилт хөдөлгөөний удирдах газартай байгуулах “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн альтернативын талаар 02 дугаар сарын 10-ны өдөр Гадаад харилцааны яаманд цахим шуудан хүргүүлэв.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Оросын Холбооны Улс, Унгар улс, Япон улсын консулын зөвлөлдөх уулзалт зохион байгуулах тухай саналыг 02 дугаар сарын 11-ний өдрийн 01/330, 01/331, 01/332, 01/333, 01/334, 01/335, 01/336, 01/337, 01/338, 01/339, 01/340, 01/341, 01/342 дугаар албан бичгээр Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлэв.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох журам, байгууллагын үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын консулын асуудал эрхэлсэн албан тушаалтнуудад хүргэхэд дэмжлэг хүссэн тухай 02 дугаар сарын 11-ний өдрийн 03/322 дугаар албан бичгийг Гадаад Харилцааны Яамны Консулын газарт хүргүүлсэн.

Оросын Холбооны Улстай хамтран стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөний саналыг 02 дугаар сарын 21-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

Бүгд Найрамдах Турк Улсын цагаачлалын байгууллагатай мэдээлэл солилцох, туршлага судлах, хамтын ажиллагааг бэхжүүлэх талаарх саналыг 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/323, 01/324 дүгээр албан бичгээр тус улсын Шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт, төсөлд хамрагдах тухай хүсэлт, холбогдох мэдээллийг 02 дугаар сарын 25-ны өдөр Туркийн хамтын ажиллагааны зохицуулах агентлаг (ТИКА)-ийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газарт тус тус хүргүүлсэн.

Түүнчлэн Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Цагаачлалын байгууллага хооронд “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулж, цагаачлал, шилжилт хөдөлгөөний байгууллагын үйл ажиллагаатай танилцан, туршлага судлах тухай саналыг 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/424 дүгээр албан бичгээр тус улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд М.П.Сингхд хүргүүлээ.

2.3. Цар тахлын нөлөөллийг бууруулах, гамшиг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дотоод хяналтын чиглэлээр:

2.3.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх:

Улсын онцгой комиссын 02 дугаар сарын 14-ний өдрийн 02 дугаар хуралдааны тэмдэглэлд дурдсан Хилийн боомт орчимд коронавируст халдварын тархалт нэмэгдэж экспорт, импортын үйл ажиллагаа тасалдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Булган, Замын-үүд, Ханги, Ганшуунсухайт, Шивээхүрэн, Цагааннуур, Боршоо, Сүхбаатар, Алтанбулаг, Эрээнцав, хилийн боомт байрлаж буй нутаг дэвсгэрт гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг тогтоож, авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээр өгсөн үүрэг болон мөн өдрийн 01 дүгээр тогтоолоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн түвшнийг бууруулж, шар түвшинд шилжүүлсэн тухай шийдвэрийг 02 дугаар сарын 15-ны өдөр төв болон орон нутаг дахь нэгжүүдэд цахимаар тус тус хүргүүлсэн.

2.3.2. Дотоод хяналт:

Байгууллагын дотоод хяналт шалгалтын чиглэлээр 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 02 дугаар сарын 11-ний өдөр нэгжийн даргаар батлуулав.

Тайлант хугацаанд байгууллагын удирдлагаас өгсөн үүргийн дагуу төлөвлөгөөт бус 3 шалгалтыг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-д заасан хугацаанд явуулж, тухайн зөрчилтэй холбоотой шалгалтын материал, дүгнэлт, саналыг холбогдох албан тушаалтанд танилцуулан, шийдвэрлүүллээ.

Байгууллагын даргын 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/12 дугаар тушаалаар Уламжлалт цагаан сарын баярын өдрүүдэд хариуцлагатай эргүүл, жижүүрийн ажиллах хуваарийг батлан мөрдөж, улсын онц чухал объектод тогтоосон журмыг сахин биелүүлэх, объектын аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 9 заалт бүхий “Зөвлөмж”-ийг 02 дугаар сарын 01-ний өдөр төв, орон нутаг дахь нэгжүүдэд тус тус хүргүүлсэн.

2.4. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын чиглэлээр:

2.4.1. Архив, албан хэрэг хөтлөлт:

Архивд баримт хүлээн авах хуваарийн дагуу 4 нэгжийн 27 албан хаагчаас 2021 оны 216 хадгаламжийн нэгжийг хүлээн авч, сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлт хийлээ.

Хууль тогтоомжийн хүрээнд 12 албан хаагчид 273 хадгаламжийн нэгжийг түр олгосон баримтын бүртгэлээр олгож, 8 албан хаагчид 51 хуудас баримтыг “Хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулж, бүртгэл хөтлөв.

Тайлант хугацаанд байгууллагын даргаас үндсэн үйл ажиллагаатай холбоотой тушаал 18, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой тушаал 32 буюу нийт 50 тушаал баталсныг цахим хэлбэрт шилжүүлж, архив албан хэрэг хөтлөлтийн программд бүртгэн, хариуцсан албан хаагчдаар үүргийн биелэлтийг хангуулан ажилласан.

Байгууллагад ирүүлсэн нийт 132 албан бичиг (хариутай 50)-ийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд шилжүүлэн, нийт 142 албан бичгийг гадагш илгээсэн

ба хяналтад 14 албан бичиг байна. Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн албан бичиг бүртгэгдээгүй.

2.4.2. Өргөдөл, гомдол:

Тайлант хугацаанд аж ахуйн нэгж, иргэн, албан хаагчаас төв байгууллагад 22 (иргэнээс 10, албан хаагчаас 12), боомт, орон нутаг дахь нэгжид 33 (иргэнээс 9, албан хаагчаас 24) өргөдөл буюу нийт 55 өргөдөл ирүүлснийг хүлээн авч, 46 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн, 9 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд хянагдаж байна. Хуулийн хугацааг сунгасан, хугацаа хэтрүүлж, шийдвэрлэсэн өргөдөлгүй.

2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

2.5.1. Программ хангамж:

Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох систем (RNSF)-ийн нэмэлт хөгжүүлэлтийн хүрээнд үүрэн утасны оператор компаниудтай байгуулах гэрээний төсөлд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Тагнуулын ерөнхий газраас тус тус саналыг нэгтгэн холбогдох оператор компаниудад 02 дугаар сарын 28-ны өдөр цахимаар хүргүүлээд байна.

“Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системийн хэрэглэгчийн шаардлагыг боловсруулан 02 дугаар сарын 20-ны өдөр “Гэрэгэ системс” ХХК-д хүргүүлсэн.

Байгууллагын цахим сайт, Eimmigration.mn сайтын нэмэлт хөгжүүлэлтээр “Оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгах, хасах хүсэлт гаргах” үйлчилгээг цахимжуулан 02 дугаар сарын 16-ны өдөр ажиллагаанд оруулав.

ISM системд мэдээлэл засварлах маягтын дагуу 2 удаагийн засвар үйлчилгээ хийж, хэрэглэгчийн 8 эрхийг шилжүүлэн сольсон.

2.6. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

2.6.1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт:

2022 оны төсөвт тодотгол хийснээр төсвийн төвлөрүүлэн захирагчийн нийт төсөв 8,699.3 сая төгрөг болж батлагдсан байна.

2022 оны 02 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр 2,374.5 сая төгрөгийн санхүүжилт авч, 1,000.7 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан, холбогдох санхүүгийн баримт материалыг бүрдүүлж ажиллалаа.

Төсвийн шууд захирагч нарын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тухайн орон нутгийн харьяа Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитаар орон нутаг дахь нэгж тус бүр “Зөрчилгүй” санал дүгнэлт авч ажилласан.

Төсвийн төвлөрүүлэн захирагч болон Төсвийн шууд захирагчийн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хуулийн хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж баталгаажуулав.

Шилэн дансны тухай хуулийн дагуу www.shilendans.gov.mn сайтад төв болон орон нутаг дахь газар, хэлтсээс төсөвтэй холбоотой 34 мэдээлэл, хөрөнгө оруулалтын 42 мэдээлэл, бусад 48 мэдээлэл буюу нийт 124 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.6.2. Орлого төвлөрүүлэлт:

2022 оны 02 дугаар сарын байдлаар Голомт банкны 1320000052 тоот төгрөгийн дансанд улсын тэмдэгтийн хураамжийн орлого болох 113.6 сая төгрөг, 130512499 тоот долларын дансанд улсын тэмдэгтийн хураамжийн орлого болох 4778 ам.долларын буюу 16,8 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлээд байна.

2.6.3. Худалдан авалт:

2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 5 нээлттэй тендерийн нээлтийн ажиллагааг зохион байгуулж, 3 тендерийн үнэлгээг хийсэн.

Тендерт шалгарсан тухай 01/415, 01/419 дүгээр албан бичгийг “Петро стар” ХХК, “Бат зүү” ХХК-д тус тус, Тендерт шалгараагүй тухай 01/414, 01/416, 01/417, 01/418 дугаар албан бичгийг “Тайгын Шим” ХХК, “Магнай Трейд” ХХК, “Сод Монгол” ХХК, “Шунхлай” ХХК-д тус тус хүргүүллээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтаар “Нормын хувцасны багц 2”-ыг дахин зарлаж, мөн хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу “Үнэлгээний хороо”-оос гэрээ байгуулах зөвлөмж, тендерт оролцогчдод мэдэгдлийг захиалагчид хүргүүлсэн.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах саналыг 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/375 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүллээ.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас ирүүлсэн зөвлөмжид дурдагдсан байгууллагад бүртгэлтэй автомашины жагсаалтыг Авто тээврийн үндэсний төвөөс гаргуулан, уг зөвлөмжид тусгагдсан статистик мэдээг орон нутаг дахь газруудаас хүлээн авч, нэгтгэв.

2.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын чиглэлээр:

2.7.1. Хяналт-шинжилгээ:

Гадаадын иргэний бүртгэл, хяналтын 01 дүгээр сарын статистик мэдээг 02 дугаар сарын 01-ний өдрийн 01/303 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд, байгууллагын 01 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээг мөн өдрийн 01/304, 01/305, 01/306 дугаар албан бичгээр Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлж ажилласан.

Байгууллагын хэмжээнд 2021 онд иргэн, аж ахуйн нэгж байгууллага, албан хаагчаас ирүүлсэн өргөдөл, гомдолд хяналт-шинжилгээ хийж, 96.4 хувиар үнэлэгдсэн шийдвэрлэлтийн тайланг 02 дугаар сарын 14-ний өдөр удирдлагад танилцуулсан.

2.7.2. Аудит, нийцлийн чиглэлээр:

Байгууллагын даргын 02 дугаар сарын 08-ны өдрийн “Захиргаа, удирдлагын газрын хүний нөөцийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх тухай” 10/02 дугаар удирдамжаар аудит явуулж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын цахим хуудаст байршуулсан 01 дүгээр сарын мэдээлэлд хяналт тавьж ажиллав.

2.8. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Тайлант хугацаанд орон нутаг дахь нэгжүүдийн дарга нараас 18 тушаал (үндсэн үйл ажиллагаатай холбоотой 7, хүний нөөцтэй холбоотой 11) баталсныг бүртгэж, хэрэгжилтэд хяналт тавин, биелэлтийг тооцон ажиллалаа.

Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссын 2021 оны 12 дугаар сарын хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэний дагуу Агаарын замын боомт хариуцсан газар 2014-2018 оны 177 хадгаламжийн нэгжийн 32,295 хуудас бүхий баримт бичгийг 02 дугаар сарын 25-ны өдөр Хан-Уул дүүргийн 12 хорооны нутаг дэвсгэрт байрлах Морингийн давааны хогийн цэгт шатааж устгал хийв.

Орон нутаг дахь нэгжүүд 2022 оны сургалтын төлөвлөгөөний дагуу хууль, эрх зүй болон хувь хүний хөгжил, харилцааны чиглэлээр нийт 11 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна.

Мөн бусад төрийн байгууллагуудаас хууль эрх зүйн чиглэлээр зохион байгуулсан нийт 12 удаагийн сургалтад давхардсан тоогоор орон нутаг дахь нэгжийн 128 албан хаагч хамрагджээ.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар баригдаж байгаа Замын-Үүд авто замын боомтын цогцолбор барилгын ажил 02 дугаар сарын 08-ны өдрөөс хэвийн үргэлжилж, зорчигчийн хэсэг 52 хувь, ачаа тээврийн хэсэг 37 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус боомтын барилгын гүйцэтгэлд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 104 иргэн оролцож байгаад Дорноговь аймаг дахь газраас хяналт тавин ажиллаж, зөрчил үүсээгүй.